

Эрүүл мэндийн газрын долоо хоногын мэдээ

Нэг. Зарим статистик үзүүлэлт

Нийт төрөлт - 55
Амьд төрөлт - 55
Амьгүй төрөлт - 0
Дутуу төрөлт - 2
Нялхсын эндэгдэл - 1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0
Эхийн ноцтой хүндрэл - 0
Төрөлхийн гажиг - 0
Гэрийн төрөлт - 0

НЭГ. АМБУЛАТОРИД СУУРИЛСАН ТАНДАЛТ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 14 дүгээр долоо хоногт нийт 4769 хүн үйлчлүүлсний 197(4.1%) нь ТТӨ -тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0,8 %-иар буурсан үзүүлэлтэй байна.

ХОЁР.ЭМНЭЛЭГТ СУУРИЛСАН ТАНДАЛТ

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (259)-ийн дотор буюу 19,6 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 2,1%-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 398 дуудлагын 101(25,3%)-ийг ТГ -ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 4,5 %-иар буурсан үзүүлэлтэй байна.

Үйл ажиллагаа

1. “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” өдөрлөг зохион байгуулсан тухай

“Авто ослоор алагүрсээ алдсаар байх уу” өдөрлөг зохион байгуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын 360 тоот албан бичгийг харьяа эрүүл мэндийн 28 байгууллагуудад 04 дүгээр сарын 04-ны өдөр хүргүүлсэн.

Өнөөдөр орон нутгийн 11.00 цагаас эхлэн аймгийн өвд Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, аймгийн өвийн 4 өрхийн эрүүл мэндийн төв, Зооноз өвчин судлалын төв, Сансар эмнэлэг зэрэг 20 эрүүл мэндийн байгууллагын 400-аад эмч, мэргэжилтнүүд автомашин ихээр зорчдог гол гол замууд дээр зогсож автомашинтай жолооч нарт сурталчилгаа нөлөөллийн ажлыг хийсэн.

Хийсэн ажлын талаар орон нутгийн “Дербес” телевиз, монцаме агентлагийн орон нутгийн салбар, орон нутгийн 21 цагийн радиогоор сурталчилгаа хийсэн. Энэхүү өдөрлөгийн арга хэмжээнд Эрүүл мэндийн газрын дарга өөрийн биеэр оролцсон ба, аймгийн цагдаагийн газарт хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлсэн боловч хамтран ажиллаагүй.

Ололт: Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 20 эрүүл мэндийн байгууллагын 400-аад эмч, мэргэжилтэн, албан хаагчид оролцож, орон нутгийн цагаар 11.00-12.00 /Улаанбаатар хотын 12.00-13.00/ цагийн хооронд жолооч нарт 18 төрлийн лоозон ашиглан осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийж, аймгийн үйл ажиллагаа явуулдаг телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд зэрэг 3 байгууллагатай хамтран ажиллаж, Эрүүл мэндийн газрын дарга С.Айгүл өдөрлөгийн тухай эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр мэдээлэл өгсөн.

Дутагдал: Жолооч нарт тараах материал хангалтгүй байсан.

Бэрхшээл: 04 дүгээр сарын 11-ны өдөр өдөрлөг зохион байгуулах тул замын хөдөлгөөнийг зохицуулж өгөх талаар албан бичгийг аймгийн цагдаагийн газарт хүргүүлсэн боловч хамтран ажиллаагүй, холбогдох бусад байгууллагуудын оролцоо хангалтгүй байсан.

2. Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Сургалтын хяналтын тоо, зардал батлах” тухай А/121 тоот тушаалын дагуу аймгийн нэгдсэн эмнэлэгийн дотрын 1 эмч Зүрх судлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд, Мэс заслын нэг эмч ЭХО-гийн 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтад, Булган сумын Эх барих эмэгтэйчүүдийн их эмч эмэгтэйчүүдийн ЭХО-гийн 3 сарын сургалтад төсвийн санхүүжилтээр 2019 оны 04 дүгээр сарын 8-аас сургалтад хамрагдаж байна. Мөн сувилагч эмнэлгийн тусгай дунд мэргэжилтнүүдийн Төрөлжсөн мэргэшлийн 3 сарын сургалтад мэс засал, Хүүхэд, эрчимт эмчилгээний сургалтанд 4 сувилагч, мэргэжил дээшлүүлэх нэг сарын сургалтад 10 мэргэжилтэн тус тус төсвийн санхүүжилтээр суралцахаар гэрээ байгуулан суралцаж байна.
3. 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Эх, нярайн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Майра, Чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Х.Анжелика, Гэдэсний халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн А.Нургүл, Архивын ажилтан М.Амангүл бүрэлдэхүүнтэй ЭМГ-ын мэргэжилтнүүдийн баг Бугат сумын ЭМТ-ийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.
4. Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдэвт 2 багц цагийн сургалтыг 2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр аймагт зохион байгуулагдав. Уг сургалтанд аймгийн 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүд хамрагдав.
5. Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга Д.Цэрэндагва аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга гишүүд, Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны дарга гишүүдийг хүлээн авч уулзаж, мэдээлэл өгч, санал солилцлоо.
6. Хилийн 0165 дугаар анги, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй 2019 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, “Гар бөмбөг”-ийн нөхөрсөг тэмцээн зохион байгууллаа.

7. Хүүхдийн Өвчний Цогц Менежментийн талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ мэдээллээр хангах зорилгоор 2019.04.08-12- ны өдрүүдэд 5 хоногийн сургалтыг зохион байгуулж байна . Сургалтын нээлтэнд Эрүүл мэндийн газрын дарга С. Айгүл Хүүхдийн Өвчний Цогц Менежментийн удирдамжийг сайн мөрдөж 0-5 насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад чармайлт гаргаж сайн ажиллахыг анхаарууллаа.
Сургалтанд орон нутгийн сургагч багш Х. Арай , И. Айнагүл нар хичээл зааж оролцогчдыг чиглүүлж байна. Сургалтанд Алтай, Баяннуур, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Цэнгэл, Хотгор,Толбо зэрэг сумдын хүүхдийн тусламж хариуцсан их эмч нар болон багийн эмч нар оролцож байна.
8. Бугат, Цагааннуур, Ногооннуур СЭМТ-д хяналт үнэлгээ хийгдсэн.
9. Жирэмсэний болон нярайн хяналтыг сайжруулах, АНЭ-ийн оношлогоо, багийн эмч нарын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 6 сум, АНЭ-т ажил сайруулах 3 сарын хугацаат аян зохион байгуулах үүрэг даалгавар хүргүүлээ.
10. 1-р улиралд Мейрим ӨЭМТ-өөс эндсэн хүүхдийн эндэгдлийг 3 тохиолдлыг магадлан хэлэлцэх хурлыг зохион явуулж, дүгнэлт гаргаж хугацаат үүрэг даалгавар хүргүүлээ.